# НИЙСЛЭЛИЙН
# ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
# ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 07 сарын 06 өдөр Дугаар 04/398 Улаанбаатар хот

Чингэлтэй дүүргийн Засаг даргын
Тамгын газрын балансад бүртгэлтэй
барилгыг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 110 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын А/935 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цагдаагийн Ерөнхий газрын мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн галын шинжээчийн 2018 оны 68/144 дүгнэлтээр шатсан болох нь тогтоогдсон Хан-Уул дүүргийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэр байрлах 235,611,829 /хоёр зуун гучин таван сая зургаан зуун арван нэгэн мянга найман зуун хорин есөн/ төгрөгийн үнэ бүхий Чингэлтэй Ахмадын амралт, сувилал" ОНӨААТҮГ-ын "Ногоон булаг" амралтын хавсралтад заасан барилгыг акталж, данс бүртгэлээсээ хасахыг Чингэлтэй дүүргийн засаг даргын Тамгын газар /Б.Цэрэн/-т зөвшөөрсүгэй.

2. Өмчийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний өөрчлөлт хийж ажиллахыг Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар /Б.Цэрэн/-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Рэнцэнбямбад даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ҮНЭНБАТ

1150500009 47

Нийслэлийн Өмчийн ашиглалт удирдлагын газрын даргын
2020 оны 07 дугаар сарын 06-ний өдрийн
01398 тушаалын хавсралт

1119282495 2576589

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГА

| № | Эд хөрөнгийн нэр | Ашигласан жил | Ашиглалтанд орсон он | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нийт үнэ | Байгуулсан элэгдэл | Үлдэгдэл үнэ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Амралт сувиллын байр | 15 | 2005 | ш | 1 | 235,611,829 | 41,132,144.97 | 194,479,684.03 |
| Нийт | | | | | | 235,611,829 | 41,132,144.97 | 194,479,684.03 |